

БАРУУН-УРТ СУМЫН 9 ДҮГЭЭР САРЫН МЭДЭЭ

ТӨРИЙН УДИРДЛАГЫН БОДЛОГО:

Архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр:Тайлант сарын байдлаар Тамгын газраас 44 бичиг явж, 34 бичиг ирсэн байна.Үүнд:

Хариутай бичиг-12, хугацаандаа явсан-8, хугацаа болоогүй-4 байна.

Тус Тамгын газраас явсан бичгийг стандартын дагуу зохион бүрдүүлж ажилласан. Мөн ирсэн албан бичгийг удирдлагад цаг тухай бүрт танилцуулан холбогдох мэргэжилтэнд хүлээлгэн өгч, барагдуулалтад хяналт тавьж ажиллалаа.

Тайлант сарын байдлаар Засаг даргаас 52 захирамж гаргасан.Үүнд:

“А” захирамж-10, “Б” захирамж-,

Тамгын газрын даргаас “А” тушаал-10, “Б” тушаал-1 тус тус гарсан байна.

“Малын А” дансны лавлагаа авах хүсэлт гаргасан 7 иргэнд лавлагаа гарган өгсөн.

Багийн Засаг даргаас 350 иргэнд тодорхойлолт гаргаж үйлчилсэн.

Төрийн үйлчилгээний оператораас 163 иргэнд лавлагаа үйлчилээ гаргаж үйлчилсэн. Төлбөртэй үйлчилгээ-21, төлбөргүй-142 үйлчилгээ байна.

Тамгын газраас хийж хэрэгжүүлсэн ажил, арга хэмжээг олон нийтэд мэдээлэх зорилгоор орон нутгийн BBS тв, Сүхбаатарын өнгө сонин, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран 4 удаа мэдээлэл нийтэлсэн.

Багийн Засаг дарга нар айл өрхөөр явж иргэдийн санал хүсэлтийг сонсож ажилласан.

Тус Тамгын газраас 5 дах жилдээ “Найрсаг Баруун-Урт -Театр” өдөрлөгийг арга хэмжээг зохион байгууллаа.Арга хэмжээнд нийт 11 төрийн байгууллага, 9-н багийн 4200 гаруй иргэн, аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгч, Засаг дарга оролцож, иргэдийн санал хүсэлтийг сонсож, хариу өгч, төрийн үйлчилгээг иргэдэд газар дээр нь хүргэж, ажилласан.Мөн өдөрлөгийн үеэр иргэдэд шинээр гарсан хуулийн мэдлэг олгох зорилгоор гарын авлага тарааж, сугалаа зохион байгуулсан.Сугалааг аймаг, сумын ИТХ-ын төлөөлөгчид ивээн тэтгэж явуулсан. Уг өдөрлөгийн зорилго нь иргэдэд төрийн үйлчилгээг сурталчлан таниулах, ойртуулах, иргэн төрийн хамтын ажиллагааг бэхжүүлэх байсан бөгөөд Засаг даргын ажлын алба бүрэн бүрэлдэхүүнээрээ ажиллаж дэвшүүлсэн зорилгоо биелүүлж ажилласан.Өдөрлөгийн үеэр аймгийн ХЖТ-тай хамтран урлагийн тоглолтыг иргэдэд хүргэн, урлаг соёлыг сурталчлан ажиллалаа.



Сумын итх-ын 2023 оны 12 дугаар сарын 19-ны 15/08 тоот тогтоолоор батлагдсан Багийн хөгжлийн хөтөлбөрийн хүрээнд багийн хэсгийн ахлагч нартай гэрээ байгуулах ажлыг өнөөдөр зохион байгууллаа.

Иргэдэд хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг танилцуулах цаг үеийн мэдээллээр тухай бүр хангаж; иргэдэд төрийн үйлчилгээг ойртуулах зорилгоор хэсгийн ахлагч нарыг ажиллуулахаар болсон билээ. Тиймээс сумын Засаг даргын 15/08 тоот захирамжаар хэсгийн ахлагч нарын ажиллах журмыг баталж, хэсгийн ахлагч нараар ажиллах иргэдэд танилцуулж, гэрээ байгуулах ажлыг зохион байгуулж ажиллалаа.



Хууль эрх зүйн чиглэлээр:Тайлант сарын байдлаар дараах хууль тогтоомжийг хяналтад авч, хугацаанд нь тайлагнаж, үр дүнг тооцож ажилласан.Үүнд:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 7-38 заалтыг хяналтад авч, биелэлтийг 8 удаа тайлагнасан.Биелэлт 78.57 хувьтай,

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн 6 заалтыг хяналтад авч, 6 удаа тайлагнасан. Биелэлт 35.0 хувьтай,

Аймаг хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлийн 3 заалтыг хяналтад авч, 80 хувьтай,

Аймгийн Засаг даргын 220-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хагас жилийн байдлаар 159 арга хэмжээг хяналтад авч үр дүнтэй-69, тодорхой үр дүнд хүрсэн-42, эрчимжүүлэх шаардлагатай-23, үр дүнгүй-13, тодорхой үр дүнд хүрсэн 8, хэрэгжилтийн дундаж-81.3 хувьтай,

Аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөний 33 заалтыг хяналт авч хэрэгжилтийг хагас жилийн байдлаар хугацаанд нь үр дүнтэй тайлагнасан.Үүнд:

Үр дүнтэй-9, тодорхой үр дүнд хүрсэн-9, эрчимжүүлэх шаардлагатай-10, үр дүнгүй-13, тодорхой үр дүнд хүрсэн 5, хэрэгжилтийн дундаж-61.52 хувьтай,

Аймгийн Засаг даргаас сумын Засаг даргатай байгуулсан гэрээний 72 заалтыг хяналт авч, хэрэгжилт 70.17 хувьтай тайлагнасан. Үүнд:

100%-19, 90%-5, 70%-19%, 50%-4, хугацаа болоогүй 6 арга хэмжээ байна.

Тамгын газрын хагас жилийн тайланг РР хэлбэрээр гарган аймгийн ХШУДАХ-т хугацаанд нь тус тус тайлагнасан.

Байгууллагын даргаас гаргасан шийдвэрийн хууль эрх зүйн үндэслэлийг хянан, зөрчилгүй эрх зүйн шийдвэр гаргаж хэвшсэн.Захиргааны шийдвэр бүрд хяналтын дагалдах хуудас цахимаар хөтөлж байгаа бөгөөд дагалдах хуудсанд захиргааны

шийдвэр боловсруулахад оролцсон албан хаагч бүрийн нэр, албан тушаал, оролцоо, гүйцэтгэлийг тэмдэглэж байна.Тайлангийн хугацаанд нийт 350 гаруй шийдвэр хянасан.

2023 оны 3 дугаар улирлын байдлаар тус Тамгын газарт хандаж 2726 өргөдөл, гомдол ирсэн байна. Үүнд:

-Бичгээр-1210, утсаар-380, цахимаар-250, биечлэн-886 өргөдөл тус тус ирсэн. Үүнийг ангилвал:

1. Шагнуулах хүсэлт- 181/ Төрийн шагнал хүссэн/-
2. Буцалтгүй тусламж-128
3. Өвс олгохыг хүссэн-940
4. Үйл ажиллагааны зөвшөөрөл-61
5. Үрчлэлт-7
6. Асран хамгаалагч тогтоох тухай-8
7. Газрын асуудлаар-26
8. Малжуулах-13
9. Гэр хүссэн-164
10. Улсын тэмдэгтийн хураамжийн буцаалттай холбоотой -23
11. Архивын лавлагаа хүссэн-84
12. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой кейс-101
13. Боловсролын асуудлаар хандсан-197
14. Сувилалд хамрагдах-89
15. Нохой устгуулах талаар-20
16. Түлээний дэмжлэг-50
17. Мал алга болсон-92
18. Чип төсөл-30
19. Гарц гаргах тухай-15
20. Бусад-497

Өргөдөл, гомдлын барагдуулалт 100%-тай байна.3 дугаар улирлын байдлаар улирлын тайланг 3 удаа гарган хугацаанд нь аймгийн Засаг даргын Тамгын газарт хугацаанд нь хүргүүлсэн.

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас жилийн байдлаар 1 удаа, 3 дугаар улирлын байдлаар 1 удаа тус тус хяналт хийж, биелэлт үр дүнг тооцон ажиллаж, удааширсан арга хэмжээг хяналтад авч, хэрэгжилтийг ханган ажиллахыг холбогдох албан хаагчдад зөвлөж ажилласан.Үүнд нийт 34 зорилтын хүрээнд 130 арга хэмжээ төлөвлөн хэрэгжүүлснээс үр дүнтэй-69, тодорхой үр дүнд хүрсэн-121, эрчимжүүлэх шаардлагатай-19, үр дүнгүй-10, хэрэгжилтийн дундаж-72.99 хувьтай байна.

Албан хаагчдийн 3 дугаар улирлын гүйцэтгэлийн тайланг журмын дагуу үнэлгээний ажлын хэсэг үнэлж, дүгнэн зөвлөгөө, чиглэл өгч ажилласан.

“Зөв хэвшил-зөв амьдрал” хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын хүрээнд дараах ажлууд хийгдлээ.Үүнд:

Албан хаагчдын 6 настай хүүхдэд зориулсан шинэ сурагч өдөрлөгийн арга хэмжээг сэтгэл зүйч Д.Оюун, эцэг эхийн зөвлөлтөй хамтран зохион

байгуулсан.Өдөрлөгт нийт 11 сурагч, эцэг эхийн хамт оролцсон.Мөн эцэг эхчүүдэд нь СӨБ-оос ЕБС-д элсэн суралцах онцлог, хүүхэдтэйгээ хэрхэн ажиллах талаар зөвлөгөө, мэдээлэл өгч ажилласан.

4 албан байгууллагын 100-аад албан хаагчдад сэтгэл зүйн сургалт өгсөн.

Ганчаарчилсан зөвлөгөөг иргэдэд тогтмол өгч байна.

Холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран зорилтот бүлэг рүү чиглэсэн сургалт, подкаст, өдөрлөг зэрэг нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж байна.

НҮБ-ийн хөгжлийн хөтөлбөрөөс хэрэгжүүлж буй “Шийдвэр гаргах түвшинд жендэрийн тэгш байдал, эмэгтэйчүүдийн оролцоог дэмжих нь” төслийн хүрээнд Сонгуулийн Ерөнхий Хороотой хамтран хэрэгжүүлж буй “Хариуцлагатай сонгогч” бэлтгэх сургалтыг 2023 оны 09 дүгээр сарын 15,16-ны өдрүүдэд амжилттай зохион байгууллаа.

Тус сургалтад Сүхбаатар аймгийн мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд суралцдаг 5 сумын 17-19 насны 25 сурагч хамрагдаж сертификат гардаж авлаа. Сургалтын явцад оролцогчдод:

- Сонгууль ба сонгох, сонгогдох эрх
- Сонгуулийн үйл явцыг ойлгох нь
- Хариуцлагатай сонгогч байх нь гэсэн 3 модулийн хүрээнд 9 сэдвээр хичээл орсон бөгөөд сургалтын явцад мини сонгууль зохион байгуулах, ханын сонин, тараах материал бэлдүүлэх зэрэг сурагчдын оролцоонд тулгуурласан, интерактив аргаар сурагчдад мэдлэг, мэдээлэл олгож буйгаараа онцлог болсон.

Хүнс, хөдөө, а ахуйн чиглэлээр:Жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Найрсаг Баруун-Урт” үзэсгэлэн худалдааг 2023 оны 09 дүгээр сарын 22-ны өдөр төв талбайд зохион байгууллаа. Тус үзэсгэлэн худалдаанд 9-н багийн 33 иргэн, 5 аж ахуй нэгж байгууллага 55 нэр төрлийн төмс, хүнсний ногоо, сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг, гурил гурилан бүтээгдэхүүн, гар урлал, оёмол бүтээгдэхүүн, морины хэрэгсэл, үндэсний хувцас, эсгий эсгий эдлэл, модон эдлэл, зэрэг олон төрлийн бүтээгдэхүүн тавигдаж, 15000000 төгрөгний борлуулалт хийн орлого олсон.



Сумын хэмжээнд 12 аж ахуй нэгж байгууллага, 60 иргэн тариалалт эрхэлж эхний ээлжинд хүлэмжинд ургуулсан нарийн ногоо 10 тн хураан авч, хүнсэндээ хэрэглэн,

худалдан борлуулж байна. Мөн Найрсаг Баруун-Урт 2023 үзэсгэлэн худалдаанд нийт 2 аж ахуй нэгж, 10 иргэн өөрийн тариалсан хүнсний ногоогоор оролцсон.

Баруун-Урт сумын Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 09-ны өдрийн А/227 тоот захирамжаар цэцэг өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцинжуулалтын мэдээ малчин өрх-512, хурга-72181 толгой малд дархлаажуулалтын ажил арай дуусаагүй байна.

Төл малыг бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын Засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн А/241 тоот захирамжаар төл малын дархлаажуулалтын явцын мэдээ: өрх-462 тугал-5761, хурга-35746, ишиг-19703 нийт-61210 толгой малд вакцин хийгдэж байгаа.

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд: Угаалганд тэмээ-5, үхэр-1621, хонь-42992, ямаа-15937 нийт-60555, туулгалтад хонь-10787, ямаа-6532 адуу-120, нийт-17439, боловсруулалтад хонь-12439, ямаа-6387, гуурын боловсруулалтад үхэр-1500 нийт-20326, бүгд-98320 толгой мал хамрагдаад байна.

Ариутгал халдваргүйтгэлд: хашаа хороо-85.2м², худаг уст цэгт-18.4 м², устгалын цэгт-62000м², голомтын талбай-35,6м² бэлчээрийн талбайд-87.9м² нийт-299.7м², талбайд НИСор, суперкилл бодисоор халдваргүйтгэлийг хийн ажиллалаа.

Хээлтүүлэгчийн цусны шинжилгээнд: хуц-1241, ухна-381 нийт-1622 толгой мал хамрагдан МЭГазрын лабораторит өгч ажилласан.

Галзуугийн вакцин-11,0 мян/тун авч үхэр-43, хонь-600, ямаа-190 нийт-833, ДХХ - энтериобактериоз хам вакцин-231.0 л хонь-5816, ямаа-2154 н-7950, дуут хавдрын вакцин-47.4 л үхэр-4139, боомын вакцин-8.6 л үхэр-508, листериозийн вакцин-140 л хонь-16589, ямаа-6830 нийт-23418, цусан халдвартын вакцин-290.4л үхэр-1465, хонь-9089, ямаа-5543 н-16097, бүгд-52945 толгой малд орон нутгийн вакцинжуулалтыг хийн гүйцэтгэж байна.

Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх угаалга, туулгалт, боловсруулалт болон цэцэг, бруцеллёзын тарилганы явцын мэдээг нэгтгэн Мал эмнэлгийн газарт өгч ажиллалаа.

Бог малын мялзан өвчний шинж тэмдэгт суурилсан идэвхгүй тандалтад нийт-50 малчин өрхөөс судалгааг авч, ажилласан.

Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр: Шууд худалдан авалтын журмаар доорх ажлыг зохион байгуулж холбогдох мэргэжилтэн нарт арга зүйн зөвлөгөө өгч анхан шатны баримтад хяналт тавьж анхан шатны бүрдлийг ханган ажилласан. Үүнд: 5 дугаар цэцэрлэг агааржуулалт, ерөнхий боловсролын 3 р бүрэн дунд сургуулийн цахим анги тохижуулах, агор парк гэрэлтүүлэг зэрэг ажлууд зохион байгуулагдаж холбогдох мэргэжилтэн нарт арга зүйн зөвлөгөө өгч, анхан шатны баримтыг бүрдүүлж ажилласан. Нийт шууд худалдан авалтын журмаар 3 ажил зохион байгуулж ажилласан.

2023 оны төсөвтэй холбоотой мэдээллийг тухай бүр мэдээллийн сувгуудад бүрэн байршуулсан. Үүнд:

1. УМСистемд шинэчилэгдсэн төлөвлөгөө, төсөл арга хэмжээний хэрэгжилтийг тухай бүр, 2. Шилэн дансны системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, төсөл арга хэмжээний санхүүжилт, аудитын дүгнэлт, захирамж шийдвэр, дансны хуулга, 3. tender.gov.mn сайтад худалдан авах ажиллагааны урилга 4. Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газар пэйжэд ОНХС-гийн цаг үеийн мэдээ болон урилга, 5. Төсвийн ил тод байдал төсвийн инфо график ашиглан төсвийн ил тод байдал зураг хуудас 2 байрны мэдээллийн самбар, пэйж хуудас, 9-н багийн ажлын албанд хүлээлгэн өгч байршуулсан. 6. Орон нутгийн хөгжлийн сангийн пэйж хуудасаар шинэчилэгдсэн төлөвлөгөө, батлагдсан тогтоол, төсвийн ил тод байдал зурагт хуудас, 7. Зууны мэдээ сонинд 1 урилга, 8. Байгууллагын мэдээллийн самбарт хурлын тогтоол, жагсаалт, төлөвлөгөө, 9. ERF системд 2023 оны Төсөв батлах тухай тогтоол, жагсаалт зэргийг тус тус байршуулсан.

Аймгийн засаг даргын захирамжаар 5 ажил эрх шилжиж ирсэн. Үүнээс 5 ажлыг 100 хувь цахимаар зарлан зохин байгуулсан. 3 ажил бүрэн дууссан, 1 ажил хэрэгжих шатандаа, 1 ажил тендер хүлээн авах шатандаа явагдаж байна. 2 ажлын санхүүжилтийг гүйцэтгэлийн дагуу бүрэн авч 284,160,2 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон. Сумын мөрийн хөтөлбөрийн хэрэгжүүлэх зардлаас 1 ажил 100 хувь бүрэн зохин байгуулж хэрэгжилт, гүйцэтгэлийн дагуу 50,0 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон.

Тогтвортой амьжиргаа 3 төслөөс хэрэгжүүлж буй "Сайн засаглалын үр дүнд суурилсан урамшуулал, хөтөлбөрийн хүрээнд хийгддэг жилийн гүйцэтгэлийн үнэлгээ 2023 оны 08 дугаар сарын 23-24 ний өдрүүдэд манай суманд хуваарийн дагуу 2 өдөр ажилласан. Нийт 37 үзүүлэлтийн дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хэрэгжилт, гүйцэтгэлийн баримтыг бэлтгэж дээрх үзүүлэлтийн дагуу материалыг хүлээлгэн өгч амжилттай шалгуулсан. Одоогийн байдлаар үнэлгээний дүн гараагүй 09 сарын сүүлээр гарах төлөвлөгөөтэй байна. ТА 3 төслийн газраас сүүлчийн шатны үнэлгээ хийгдэж удирдамжийн дагуу бэлтгэл бэлэн байдлыг ханган ажиллаж үнэлгээнд амжилттай хамрагдсан.

Шилэн дансны системд сар бүр оруулах бүлгийн 2 заалт, тухай бүр оруулах бүлгийн 2 заалтад хуулийн хугацаанд 100 хувь бүрэн оруулсан. Шилэн дансны системд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, Шилэн дансны тухай хуулийн 4.1.9 – т зааснаар хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж сонгон шалгаруулсан бол тендерийн ерөнхий мэдээлэл, 5,0 сая төгрөгөөс дээш орлого, зарлагын мэдээлэл, ОНХС-гийн хэрэгжилт, аудитын дүгнэлт, зэргийг тухай бүр оруулж мэдээлсэн. Хугацаа хоцорсон мэдээлэл байхгүй

Нийгмийн хамгааллын чиглэлээр:Тус сумын 9 багийн бүсийн тэмцээнээс шалгарсан 100 ахмад тамирчид аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцож 1 дүгээр байр эзэлсэн бөгөөд арга хэмжээнд 2,6 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

Залуучуудын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, сагсан бөмбөгөөр хичээллэх сонирхлыг бий болгох, хөгжүүлэх зорилготой 3х3 сагсан бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулсан. Тус тэмцээнд 9 багийн 35 багийн 105 залуу оролцсон.



Найрсаг Баруун-Урт-Театр өдөрлөгийн хүрээнд Өрхийн эрүүл мэндийн төвүүдтэй хамтран иргэдэд эрүүл мэндийн анхан шатны үзлэг, шинжилгээ зохион байгуулж, ХДХВ/ДОХ,БЗДХ, болон сүрьеэ өвчнөөс урьдчилан сэргийлэх тухай зөвлөмж, зөвлөгөө өгч,гарын авлага тараасан. Уг арга хэмжээнд нийт 2000 гаруй иргэн хамрагдаж, мэдээ, мэдээлэл авсан.



Хичээлийн шинэ жил эхэлсэнтэй холбогдуулан амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлогтой өрхийн суралцагчдад төрийн болон төрийн бус байгууллага, иргэдтэй хамтран 26 сурагчид 2.8 сая төгрөгийн хичээлийн хэрэгсэл, бараа материалын дэмжлэг үзүүлсэн.

Сум, орон нутгаа төлөөлөн Олон улсын тэмцээн уралдаан оролцож буй 4 иргэнд 3.2 сая төгрөгийн дэмжлэг үзүүлсэн.

2023 оныг "Хүүхдийн хөгжил, хамгааллыг дэмжих жил" болгон зарласантай холбогдуулан дараах ажлуудыг хийлээ. Үүнд:

Тус сумын 6 дугаар багийн ажлын албанаас Сүхбаатар аймгийн Угсаатны зүйн музей, Сүхбаатар тохижилт ОНӨААТҮГазартай хамтран танин мэдэхүйн аялалтай сургалтыг зохион байгууллаа.



Сургалт, аялалд 11 дүгээр цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн хүүхдүүдийг музейн үйл ажиллагаа, өв соёлтойгоо танилцуулах аяллыг зохион байгуулж 38 хүүхдийг хамруулаа.

Мөн хог хаягдлаа ангилан ялгадаг байгальдаа хайртай хүүхдийг бий болгох зорилгоор "Хогоо ангилж суръя" сургалтыг Сүхбаатар тохижилт ОНӨААТҮГазрын ажилтан Ц.Болортуяатай хамтран зохион байгуулсан.



Баруун-Урт сумын 8,9 дүгээр багийн ажлын алба хамтран "ХҮҮХДЭЭ СОНСОХ ӨДӨР" арга хэмжээг нийгмийн амьдралын бүхий л салбарт хүүхдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний

дуу хоолойг сонсох, хүүхдийг ойлгож хүндлэх, тэдэнд тулгамдаж буй асуудлыг тодорхойлон санал бодлоо солилцож, хүүхдүүдээс гарсан саналыг ангилан нэгтгэж шийдвэрлэх, уламжлах зорилгоор зохион байгууллаа.

Тус арга хэмжээний хүрээнд хүүхдүүдийн санал, санаачилга, тулгамдаж буй асуудлын талаар ярилцаж Сэтгэл зүйч Д.Оюун Харилцааны суурь чадвар сэдвээр мэдээлэл хүргэж, Баруун-Урт сумын эрх зүйн хөтөч нар Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн бэлтгэн гаргасан Цахим хэрэглээний 5 дүрмийн талаарх зурагт танилцуулгыг хүүхдүүдэд хүргэлээ. Хүүхдүүдээс дараах санал, хүсэлт гарлаа. Үүнд:

1. Золбин нохой устгах
2. Зам болон гудамжны гэрэлтүүлэг нэмэгдүүлэх
3. Тоглоомын талбай засварлах
4. Сэтгэл зүйчээс ганцаарчилсан зөвлөгөө авах
5. Анги, танхимын хүрэлцээг нэмэгдүүлэх
6. Явган хүний зам нэмэгдүүлэх, засварлах



Хүүхдүүдийн гаргасан саналыг багийн ажлын алба үйл ажиллагаандаа тусган ажиллахаар болсон.

Сүхбаатар аймгийн хэмжээнд 600 багшид 1,8 тэрбумын өртөгтэй компьютержуулах ажил хийгдсэн. Уг ажлын хүрээнд Орон нутгийн хөгжлийн сангаас 211 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг багшийн сургалтын үйл ажиллагаа, тасралтгүй хөгжилд зарцууллаа.



Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:

Сумын Засаг даргын 2023 оны А/249 тоот захирамжар томилогдсон ажлын хэсэг 09 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 09 дүгээр сарын 16-ны өдрийг хүртэлх хугацаанд модны мониторинг хийлээ.

ОНХСангийн хөрөнгөөр иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, идэвхжүүлэх зорилгоор 9-н багийн 72 өрхөд 333 ш монос, гүйлс, далан хальс, интоор зэрэг 4 төрлийн суулгацыг зах зээлийн үнээс 50%-ийн хөнгөлөлттэй олгосон. Уг модны суулгацад мониторинг хийхэд 283 ширхэг нь ургасан 50 ширхэг нь ургалтгүй болсон байна. Нийт модны



амьдралын хувь 85%-тай.

Төв суурин газарт хаврын тарилтаар 22157 ширхэг суулгацыг тарьсан. Үүний 22893 ширхэг суулгац нь ургасан, 2264 ширхэг суулгац нь ургаагүй. Нийт ургалт 90%-тай.

Баруун-Урт сумын агропарк 5000 ш хайлаас, шар хуайс, монос, бургас зэрэг 4 төрлийн мод тарьснаас 4500 мод ургасан, ургаагүй 500 ш суулгац ургаагүй. Ургалтын хувь-90% байна.



Нэрэмжит төгөл буюу барилгачдын талбай, наадмын талбай, боловсрол зэрэг газарт 1735 ширхэг суулгац тарьснаас 1561 ширхэг ургасан, 174 ширхэг нь ургаагүй. Амьдралын хувь нь 90%-тай.



Хамгаалалтын зурвас буюу амгалан хошуу, голын эхэнд 2250 ш суулгац тарьснаас ургалтын хувь-70 хувь буюу 1200 ш ургасан, ургаагүй-800 ш байна. Зуны 3-4 удаагийн үерт модны суулгац гэмтэж, урссан байна.

Баруун-Урт сумын хэмжээнд 2023 онд 27157 ширхэг модыг хаврын тарилтаар тарьсан. Үүний 24440 ширхэг ургасан, 2717 ширхэг нь ургаагүй байна. Модны мониторингийн нэгдсэн дүгнэлтээр амьдралын чанар 90%-тай байна.

2023 онд хур бороо элбэг, ус чийгийн нөлөөгөөр модны суулгацын амьдралын чанар өсөлт өмнөх жилүүдээс их байсан хэдий ч амгалан хорооллын баруун талаар тарьсан суулгац зуны 3-4 удаагийн үерийн улмаас урссан, гэмтсэн, ялзарсан байна.

Баруун-Урт сумын хэмжээнд ногоон байгууламжийн усалгаа арчилгааг мэргэжлийн 3 байгууллагаар хариуцан ажиллаж байна.

Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ойн анги ОНӨААТҮГ нь төв суурин болон тойргийн зэрэг нийт 8000 ш ширхэг модны усалгаа арчилгааг хийж гүйцэтгэж байна.

Шаргын модод ХХК нь Баруун-Урт сумын Засаг даргын тамгын газрын модны усалгаа арчилгааны багц 1, 2 тендерт гүйцэтгэгчээр шалгарч гэрээ байгуулан ажиллаж байна. нийт 12266 ширхэг модыг хариуцан усалгаа арчилгааг хийж гүйцэтгэж байна. Үүний 11040 ширхэг нь ургалттай, 1226 ширхэг нь ургалтгүй байна. Ургалтын хувь-90%-тай.

Тус суманд үйл ажиллагаа явуулж буй 7 мах боловсруулах болон мал нядалгааны газрын дарга, эрхлэгч нартай хог хаягдлын асуудлын талаар аймаг, сумын удирдлага,



БОГазар, Дөрвөлж ХХК оролцон хуралдлаа. Тус хурлаар Баруун-Урт хотын салхин доорх хэсэгт үнэртэж буй өмхий үнэрийг хэрхэн шийдэх тухай асуудлаар хэлэлцэж хог хаягдлын төлбөрийн үлдэгдэлтэй 5 аж ахуй нэгж төлбөрөө барагдуулах, хогийн нэгдсэн цэгт нүх ухах, цэвэрлэх байгууламжийн хуучин усны картыг булах зэрэг асуудлыг хэлэлцэн шийдвэрлэлээ. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр баригдсан цэвэрлэх байгууламж ашиглалтад орохтой холбогдуулан хуучин цэвэрлэх байгууламжийн усны картнаас өмхий үнэр гарч иргэдийн ая тухтай амьдрах, эрүүл аюулгүй орчинд амьрахад сөргөөр нөлөөлж байгаа байгаа тул Талбулгийн уурхайн техникийн ашиглан үнэр гарч буй цэвэрлэх байгууламжийн усны картыг булах ажлыг Тамгын газраас 2868800 төгрөгийн хийж гүйцэтгэсэн. 7,8-р сард орсон үерийн улмаас голын эхийн хамгааллын 51 хашаа нурж унасан. Уг хашааг сэргээн засварлах, хуучин цагаан хашааг буулган өргөтгөж Адапт төслийн татмын ойн нөхөн сэргээлт, ойжуулалт хийх газрыг хамгаалах 645 м хашаатай нийлүүлж татах ажлыг хийж байна. Уг хашааг өргөтгөсөнөөр голын эхийн 12 га газрыг хамгаалж, цаашид уг газрын ургамлын бүрхэвч сэргэх, бургас модыг хамгаалах, голын эхийг бохирдлоос сэргийлэх, мод тарих зэрэг чухал ач холбогдолтой юм. Ажлын явц-70%-тай байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 398.902.383 төгрөгийн хөрөнгөөр Худалдааны гудамжны тохижилтийн ажлыг Жавхланхүслэн ХХК хийж гүйцэтгэж байна. Тус ажлын явцтай танилцаж тухай бүр тулгамдаж буй асуудлыг холбогдох газруудад уламжилж шаардлагатай арга хэмжээг авч ажилласан. Тус ажлын явган хүний замын ажил дууссан, машин зогсоолын талбай тэгшлэх ажил хийгдэж байна.



9 дүгээр багийн нийтийн эзэмшлийн камержуулалт байршуулах тендерт шалгарсан Топика ХХК нийт 24 ширхэг камер суурилуулах ажил хийгдэхээс 15 байршилд нүүр таньдаг-2, дугаар таньдаг-2, энгийн-20 камер, Энгийн 20 камер суурилагдсан царай болон дугаар таньдаг камерын суурь нь хийгдсэн камер суурилагдаагүй байна.



Тус сумын 1-р багийн тоглоомын талбайн засвар, шинэчлэлийн ажлыг Талын баян эрхэт ХХКомпани ОНХС-ийн 56.150.600 төгрөгөөр хийж гүйцэтгэж байна.



6 дугаар багийн Барилагчдын талбайн цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт ОНХС-ийн 15.000.000 сая төгрөгөөр хийж гүйцэтгэж байна.



9 дүгээр багт байрлах зөөврийн усан сан их хэмжээний усархаг бороо орсон, ус зайлуулах хоолой байхгүйн улмаас урд талын засмал замд ус тогтож усан сангийн тоног төхөөрөмжүүд шатаж эвдэрсэн. Уг ажилтай холбоотой асуудлаар Дөрвөлж компанитай хамтран ажиллаж, ус их тогтож байгаа хэсгийн ус зайлуулах шугам байршуулан худаг хэвийн үйл ажиллагаанд орсон.




9-р багийн нутаг дэвсгэр эзэнгүй, нурсан хашааны бүртгэл судалгааг гаргаж Засаг даргад танилцууллаа. Судалгаагаар 155 газар байснаас гэрчилгээгүй буюу албан ёсны бичиг баримтгүй хашаа татаагүй 23, хашаа татсан боловч бичиг баримтаа аваагүй 24, гэрчилгээтэй боловч хашаа татаагүй 107 айл өрх байна. Хашаа татсан боловч гэрчилгээгээ аваагүй айл өрхүүдээр орж 2024 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд оруулан албан ёсны бичиг баримттай болох талаар заавар, зөвлөгөө өгч ажиллалаа.

Өнөр хорооллын айл өрхүүдээр орж албан ёсны эзэмшигч 52 брхийн судалгааг гаргасан. Тус хорооллын барилга нь 5, 7 сард орсон их хэмжээний усархаг борооны улмаас дээврээс ус гоожиж, амьдрахад бэрхшээлтэй болсон бөгөөд уг асуудлы газар дээр нь очиж, танилцлаа.

Авто зам, гэрэлтүүлгийн ажлын хүрээнд дараах ажлууд хийгдлээ.Үүнд:

ҮТП-ын гүүрэн самбараас баруун 4 замын уулзвар хүртэлх автозамын гэрэлтүүлгийн 20ш толгой солисон.



Төв замын гэрэлтүүлгийн гэмтлийг тогтоож холболт хийж, ил гарсан утсыг далдалж булсан.



Асгатын зам дагуу гэрэлтүүлгийн гэмтэл гаргаж, утас далдлалаа.





3-р тойргийн зам дагуу Эрдэнэ-Шарга дэлгүүрийн ойролцоох гэрэлтүүлгийн гэмтлийг тогтоож, утас далдалж буллаа.



Жигжиджавын садны зүүн талаас урагш 4 зам хүртэлх гэрэлтүүлгийн гэмтэл гаргаж, утас буллаа.




Дөрвөлж толгой Бурхан багшийн цэцэрлэгт хүрээлэнгийн чийдэн гэрэл засварлалаа.




Нийт 1,2,3-р багийн 5 авто замын гэрэлтүүлгийн гэмтлийг олж тогтоон холболт хийж, утас далдлах булах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Цаг үетэй холбогдуулан аймгийн хэмжээнд асаж байгаа автозамын болон цамхагт гэрэлтүүлгийн цагийн зохицуулалтыг хийж, асалт, унтралтыг 8:40-01:00 хүртэл хугацаанд асч, унтарч байхаар тохируулга хийсэн.



3-р тойргийн зам, төв зам, төмөртэйн замд нийт 34 шонгийн тэгшилгээ хийгдлээ. ---
Баруун- гүүрний 2 талын гэрэлтүүлгийг сэргээн засварлах ажлыг хийж гүйцэтгэлээ.



Орцны гэрэлтүүлгийн засварын ажлын хүрээнд дараах ажлууд хийгдлээ.Үүнд:

Жаргалан хотхон 27А байрны 2-р орцны 3 давхарт 1ш мэдрэгчтэй гэрэл, Мандал хотхоны 180 айлын орон сууцны 3-р байрны орцны гэрэлтүүлэг нийтээрээ асахгүй болсон шийтний цахилгааны холболтыг хийж, гэрэлтүүлэгийг асаалаа.



Ногоон хотхоны 100-р байрны нүүрэн тал, 103-р байрны баруун талд ус зайлуулагч агааржуулалтын хоолой угсрах ажил хийлээ.




Одкон хотхоны 1, 3-р байранд ус зайлуулагч хоолой 2ш, 38 айлын орон сууцанд 1ш ус зайлуулагч агааржуулалтын хоолой хийж гүйцэтгэлээ.

Жаргалан хотхон Дөрвөлж-12 айлын орон сууцны бохирын усны шугам хагарч, гэмтэл гарсаныг [Дөрвөлж Компани](#) засварчидтай хамран шаардлагатай материалаар ханган засах, солих ажил хийлээ.



Орон сууцны цэвэрлэгээний ажлын хүрээнд дараах ажлуудыг хийлээ. Үүнд:


Ногоон хотхоны 100-р байрны подвальд их хэмжээний борооны ус орж, тогтсон усыг фомфоор соруулах, малтаж шавхаж, асган, ариутгал хийлээ.



Мандал хотхоны 1-р байрны 1 орцны подвалын усыг шавхлаа.



Даймонд хотхон 107-р байр 1,2-р орцны дотор, гадна шилэн хаалга угааж цэвэрлэсэн.



Шарилж, зэрлэг ургамал устгалын ажлын хүрээнд нийтийн эзэмшлийн орон сууцнуудын гадна талбайн шарилж ургамлыг устгах, цэвэрлэх ажлыг хийлээ. Үүнд: Жаргалант, 27а,б,в, 36а,б, 48, 52, 6, 8, 12 айлын гадна талын шарилж ургамал, Ногоон хотхон 5 байр, Даймонд хотхон 4 байр, Саруул хотхон 5 байр, Цайрт хотхон 3 байр, Мандал хотхон 12 байр, Цэлмэг хотхоны 3 байр, Дөрвөлж хотхон 4 байр, Залуус хотхоны 5 байрны гадна орчмын нийт 10 хотхоны 56 байрны нийтийн талбайн шарилж, хогийн ургамал устгалаа.



Цэцэрлэгжүүлэлт, ногоон байгууламжийн чиглэлээр дараах ажил хийгдлээ:

Талбайн модонд хортон шавьжаас сэргийлэх, устгах зорилгоор хор цацсан.



Өнөр хорооллын урд талын саадан дах хайлаас, замын хажуу талын хайлаасыг тэгшилж, өнгө үзэмжийг сайжруулсан.



Төв талбай дээрх мандлын цэцгийг тогтмол усалж, арчилж байна.



Мод үржүүлгийн талбайн зэрлэг, хортон ургамлыг тогтмол түүж, арчилж байна.

Мод үржүүлгийн талбайн хашааг тэлэх ажил явагдаж байна.




7023м.квадрат бүхий мод үржүүлгийн зориулалттай газрыг манай байгууллагад шинээр олгосны дагуу мод үржүүлгийн талбайн хашааг тэлж байна.

Зам дагуух 102 улиасанд доод талаас нь шууж, цэвэрлэгээ хийсэн.

Хуваарийн дагуу тогтмол мод усалгаа, арчилгаа хийгдэж байна.



Гэр хорооллын хог ачих батлагдсан хуваарын дагуу 1,2,3,4,5,6,9 багуудын гэрээт 1742 айл өрхөөс хог тээврийн жолооч 3 хог тээврийн ачигч 6, ковш жолооч 1 нийт 10 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж 152 удаагийн рейсийн **1358** тонн хог хаягдлыг төвлөрсөн хогийн нэгдсэн цэгт, мөн төвийн орон сууцын 2243 айл өрх болон гэрээт 170 аж ахуй нэгжээс жолооч 2 ачигч 4 нийт 6 хүний бүрэлдхүүнтэйгээр 91 удаагын рейсээр **967** тонн хог хаягдал, төвийн ангилан ялгах хогийн савнаас 38 удаагын рейсээр 70 тонн хог хаягдал нийт **2395** тонн хог хаягдлыг ачиж тээвэрлэн шинээр ашиглалтанд орсон 2-р зэргийн хяналттай хогийн цэгт буулгаж 50 ковшоор 4 удаагын түрэлт хийж хог хаягдлыг дарж булшиллаа.



Аюултай хог хаягдал: Аймгийн нэгдсэн эмнэлэг, өрхийн эмнэлэг болон аюултай хог хаягдлын гэрээт 10 аж ахуй нэгжээс хог хаягдлын хувиар маршрутын дагуу **1865 кг**



аюултай хог хаягдлыг жолооч 1 ачигч 1 нийт 2 хүний бүрэлдхүүнтэй авч аюултай хог хаягдлыг шатаах зууханд хийж устгалаа.


Баруун-Урт сумын төвийн бүс болон ногоон байгууламжид орсон малыг гаргах ажилд жолооч мал хөөгч гэсэн 2 хүн ажиллаж сумын төв болон ногоон байгууламжийн бүсэд орж ирсэн 40 үхэр, 13 адууг хөөж ногоон бүсээс гаргалаа.

Золбин нохой устгах ажлыг 7 хоног бүрийн даваа, лхагва, баасан гаригт зохион байгуулдаг. Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын ИТХ-ын тэргүүлэгчдийн 2020 оны 12 дугаар сарын сарын 17-ны өдрийн 3/09 тоот тогтоолыг үндэслэн 2023 оны 8-р сард золбин нохой устгах ажлыг зохион байгууллаа. Үүнд Жолооч-1 Буудагч-1 тус тус ажилласан. Нийт **122** нохой устгасан.

Баруун-Урт сумын хэмжээнд хатуу хучилттай авто зам 53.4 км, явган хүний зам 52048 м2, нийтийн эзэмшлийн бусад газрыг хариуцан ажиллаж байна. Үүнд :

- Үерийн далан суваг 3,5км
- Эзэнгүй хог, сэг зэм
- Цэцэрлэгт хүрээлэн хөшөө дурсгал 24, тоглоомын талбай 24
- Шарилж устгал
- Замын тэмдэг засвар үйлчилгээ
- 3, 4, 5-р тойргын зам, талбайн цэвэрлэгээ үйлчилгээг хариуцан иргэдийг хоггүй цэвэр эрүүл орчинд аятай тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө ажиллаж байна.

9-р сард манай тасаг Давхардсан тоогоор 157км авто зам, 52000м2 явган зам **103** тн хогийг НЭЗТалбайгаас хогийн нэгдсэн цэгт хүргэж ажилласан байна.



Хог хаягдлыг эх үүсвэр нь ангилан ялгах, үүсгэгч нь хариуцах,

санхүүжилт, урамшууллын шинэ системийг нэвтрүүлэх ажлыг эрчимжүүлч 2023 оны 09-р сард хуванцар **173** кг худалдан авч нийт **43.250**, гялгар уут **784** кг худалдан авч нийт **313.600**, лааз **20** кг худалдан авч нийт **8000** төгрөг тус тус худалдан авлаа.



Дахивар дахин боловсруулах үйлдвэр нь 8-р сард нийт 65 ширхэг жижиг шон хийхдээ нэг шонд 8 кг гялгар уут, 3 кг буталсан хуванцар сав ашигласан. Нийт орц нь 520 кг гялгар уут, 195 кг буталсан хуванцар сав орсон.

65 ширхэг шон хийхэд худалдан авсан нийт гялгар уут 208.000, хуванцар сав 48.750 төгрөг болсон.



Тайлан нэгтгэсэн:

Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн:

А.Өлзийжаргал